



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/19

Чойр

“Аймгийн аварга малчин өрх”  
цол тэмдэг олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2022 оны 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрдэнэт мал сүргийнхээ тоо толгойг өсгөж, малын ашиг шимийн гарц, чанар, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг үнэлж дараахи малчдыг “Аймгийн аварга малчин өрх” цол тэмдэгээр шагнасугай. Үүнд:

Дэнсмаагийн Батмөнх (Сүмбэр сумын 4 дүгээр багийн малчин)

Цэрэнжамцын Алтанзул, эхнэр Самбуумаагийн Одгэрэл (Сүмбэр сумын 4 дүгээр багийн малчин)

Дашзэвгийн Пүрэв-Очир, эхнэр Баттөмөрийн Оюунжаргал (Сүмбэр сумын 5 дугаар багийн малчин)

Очирбатын Түвшинжаргал, эхнэр Шагдарын Энхцэцэг (Сүмбэр сумын 6 дугаар багийн малчин)



Батцэнгэлийн Хашхүү, эхнэр Төмөрхуягийн Энхзул (Шивээговь сумын 2 дугаар багийн малчин)

Батдоржийн Тойруул, эхнэр Эрдэнэ-Очирын Янжмаа (Баянтал сумын 1 дүгээр малчин)

2.Аймгийн аврага малчин өрх тус бүрийг 1,000,000 (нэг сая) төгрөгний үнэ бүхий зүйлсээр шагнасугай.

3.Шагналд зарцуулах 6,000,000 (зургаан сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТЗАМ